

**МОНГОЛ ХЭЛНИЙ “МАШ” ХЭМЭЭХ ҮГ БОЛ
МАШИД НЯГТАЛМААР ҮГ...**

(Үг, өгүүлбэрийн амь амьдрал, утга соёл, хэрэглээ)

**Б. Пүрэв-Очир¹
Д. Баасанбат²**

*Монголын үрс маш олон болтугай.
Д.Нацагдорж*

Монгол хэлэнд “маш, машид, ашид, эгнэгт, үүрд, нэн, тун, үлэмж...” гээд л машид судалж нягтлан сонирхмоор үг, хэллэг өдий төдийгөөр байдаг. Эдгээр үгсийг бичиж боловсруулсан зүйлдээ хэрэглээгүй, хэл яриандаа хэлээгүй монгол хүн тун ховор байх аа. Хүмүүн хоорондын харилцаанд эерэг сэтгэл хөдлөл, зохист эрчим долгионыг илэрхийлсэн үедээ “маш сайхан, машид бүтэмжит, маш бат, машид гүтгэсэн чимэг, машид ариун, үүрд энх, нэн цэвэр, тун уран, маш номхон, машид зөөлөн, маш үнэн, маш тустай, маш сайхан, үлэмж арвин...” гм-ээр, сөрөг үнэлэмж, таашаал, тааруухан эрчим долгионыг илэрхийлэх тухайдаа “маш муухай, маш хэврэг, маш эмзэг, маш хорт, маш худалч, маш бэрх, маш гашуудах, машид харамсах, эгнэгт худал, нэн зохисгүй, тун базаахгүй, үлэмж ховор...гм-ээр, хэрэглэсээр иржээ. Монгол хэлний энэхүү “маш” тэргүүтэй бүлэг үгсийг монгол хэлзүйн сурах бичгүүд, судалгаа шинжилгээний ном зохиол, сургуулийн хэлзүй, толь бичиг зэрэгт гадаад, дотоодын эрдэмтэн судлаач нар, “дайвар үг, сул үг, хүч нэмэгдүүлэх үг, баймж үг, утга эрчимжүүлэх үг, орон цагийн нэр” гм-ийн нэр томъёогоор оноож, янз бүр өнцгөөс тайлбарласаар ирж. Яахлаараа ийм үгсийн бүлгийг “дайвар бүтээгдэхүүн, дайвар гуйвар юм, дайвар мах, дайвар эрхтэн” гэдэг шиг дайвар үг гэсэн юм болдоо? Эсвэл “сул яриа, сул оюутан, сул морь, сул сувс, сул шороо, сул асгасан сувд” гэдэг шиг “сул үг” гэж нэрлэсэн юм болдоо? гээд л сонирхоод үзмээр санагдана. Гэтэл бас энэхүү утга эрчимжүүлэх, хүч нэмэгдүүлэх “**маш, машид**”-тай зэрэгцээд л Маш, Машбалжир, Машбат, Машбаян, Машбилэг, Машбүтэмж, Машдэлгэр, Машлай, Маштунгалаг гм хүний оноосон нэрийн “**Маш~Маши**” (айдаггүй, эрэлхэг зоригтой, аймшиггүй, хашир, авхаалжтай, бүтэмжтэй гэсэн утгаар: Osmanliva, Turkce Lugat, Анкара, 2001, х-583), **машлах** (юмыг үүрд, эгнэгт өгөх, машлан татах), “**маш авах, маш өгөх**” (хэр хэмжээ, цаг заах утгаар: С.Шагж гуайн тольд тэмдэглэсэнээр.) **машлан барих**(буугаа цэнэглэн барих), **маш холбон буудах**(баяд аялгуунд: онь холбон буудах, гохийг зэрэг дарах), **машин тэмээ** (халх аялгуунд: хоёр бөх ширээ боловч урагш махийсан буюу урд бөх

¹ МУБИС-ийн Монгол судлалын сургууль.

² МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

урагш махийсан, соёо бөхтэй тэмээ, **машуурах** (адуу болон тэмээний мах\цээр нэр\–ыг идсээр байгаад уйдсан, эсвэл бялуурсан) утгат үг байна. (Д.Баасанбат, ”Монгол хэлний тунгаамал”, 2010, 173-р тал.), **бууны маш** (ойрд аялгуунд: бууны хуй буюу хундага мод, адууны мах\ машин мах\), **маш дарах** (баяд **аман аялгуунд**: гох дарах, маш холбож буудах\зэрэг дарах\, машин мах (тэмээний мах), (буриад аялгуунд: **машин дэгээ-гэгээ** (өвсний том нуруу буюу бухлаас өвс татан буулгадаг ганц шүдэт махир дэгээ), **машийн мах** (адууны мах), **машлах** (арвилах гамнах гэсэн утгатай), **“машан”** (зэр зэвсэг), **“машанга”** (түнгүс манж хэлэнд хашир авхаалжтай) гм. Үйл үг, тогтвортой холбоо үг хэлц үгийн дотор **“маш”** язгууртай нэр ба үйл үгс хэрэглэгдсээр, монгол төрөл хэл, аялгуунд утга нь өргөжсөөр, тэлсээр ирсэн нь баримтаас харагдаж байна. Эндээс үүдүүлэн бодвоос, монгол хэлний **“маш”** язгууртай үгсийг үгийн гарваль зүйн үүднээс нь, түүхэн хувьсал өөрчлөлтөөс нь, хийсвэр ба бодот утгын талаас нь, соёл-хэлшинжлэл, нийгэм-хэлшинжлэл, танин-мэдэхүйн хэлшинжлэл, тархац хэлшинжлэлийн талаас нь сонирхон үзэж, **“маш”** –ийн эргэн тойронд эргэлдэж үзвэл сонин содон хэдэн зүйл юм байх шиг.

Нэгэн зүйл : “Маш”-ийг хэрэглэж ирсэн байдал, утга соёлын талыг нь нягталж үзвэл, монголчууд, 14 оронг их тоог “маш дэлгэмэл”, “маш тунгаамал” гм-ээр тоо тооллын үг нэр томъёонд, “машлах” буюу юмыг үүрд өгөх, “маш дор орох”, “маш байх” гэх мэт үйл үгийн хэлбэрээр (Цэцэнцогт гуайн “Монгол үгийн язгуурын толь”-д буйгаар), Ер өчүүхэн эрдэмтэн дэмий омогтой явах Их эрдэм төгссөн мэргэд маш номхон байх (зүйл:-104х-42), Манлай сайн мэргэдэд элдэв зүйл эрдэм байх Муу тэнэг хүнд элдэв зүйл гэм байх Магад сайн эрдэнээс олон хэрэгтэн гарна за Маш хорт могой олон өвчин төрүүлэх мэт (зүйл:-107), Маш үнэн зөв явтлаа, гэмт болох ч байдаг бөгөөд Манлай сайн мэргэд гэмд үл авьюу(зүйл:-126), Муу хүн хэзээд эс тэнхэрвэл Магад тэр болтлоо сайн зантай байх Муу хорт өргөсүүд эс хатгалаа Машид зөөлөн ногоо мэт байх(зүйл:-147), Малын сүүг бусад амьтанд уулгавал тэжээл болно за Маш хорт могойд уулгавал хор нь ихэдьюү(зүйл:-177), Маш худалч гэж алдаршаад олонд хөнгөрөх Магад үнэн боловч эцэст нэгэн аюул болох(зүйл:-180), Үлгэрлэвэл зандан маш сэрүүн чанартай боловч Өнө удаан хавирвал халж гал гарах мэт(зүйл:-198), Магадлан мэдээд үнэн зөвөөр явах нь Маш сайн бөгөөд хотол төгсөхийн шалтгаан(зүйл:-300), Сайтар мэдэх чадалт хүн хичээж явбал Саваагүйн гэм гарах нь маш хол(зүйл:-315), Хэтэрхий хурц ухаан ба асрах зөөлөн сэтгэл Хэзээд бусдыг үйлийг бүтээх ба баатар зориг тэргүүтэн Хэр мэт ёсчлон чадах маш бэрх боловч Хэрэгтэй эрдмийн зүйлийг аль чадахаар судалтугай(зүйл:-357), Алс хэзээд маш тустай эрдэм мөн бөгөөд Анх даруйдаа зовиуртай боловч хичээн судалтугай(зүйл:-386), Маш их үйл хэргийг бүтээхэд Манлай сайн эрдэмт нөхрийг олж шүттүгэй Маш зузаан ой шугуйг түймэрдэх болбол Магад нэгэн салхи нөхөр болох хэрэгтэй мэт(зүйл:-396), Энэ бүхэл насандаа зоригоор жаргасан жаргалангаас Эцэс хойтод зовохын зовлон маш үлэмж их(зүйл:-416), Ухаантан мэргэд сайтар номлосон судраан Утга чанар маш сайхныг мэдэх бөгөөтөл

Огоот түүний утгыг эс эдэлбэл Учир утга хэдий мэдэвч ер юун хэрэг(зүйл:-448), (Эрдэйн сан субашид. 1990.) гэх мэтээр эртний уран зохиолд,

... Тэмүжин Мэнлигийн хамт маш яаран 3 өдөр 3 шөнө довтлон гэртээ ирээд эцэг таалал төгссөнд маш гашуудан газар унан уйлж гашуудсаар муужрахад үнэнч боол Чирха түүнийг сэргээж ятган хэлсэн нь:(х-270), ...Ийнхүү Есүхэй баатрын гэр бүл нэг хэсэг хугацаанд маш ядуу зүдүү байдалд оршиж байжээ. (х-28), ...Тэмүжин хайлс

холтсоор гэр барьж хэд хоноод Мэргэдүүд бүр мөсөн явсан мэдээг авмагц уулнаас буун гэртээ ирэхэд Бөртийг Мэргэдүүд барин авсныг мэдээд маш их гашууджээ.(х-39), ...Тэмүжин өөрөө амь гараад сэтгэл амарсан биш харин амраг Бөртэ алдсанд машид харамсан хэрхэн түүнийг аврах арга замыг эрэхдээ юуны урьд Хэрэйдийн Ван ханаас тусламж авахыг бодон ...(х-40), (Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг 1991) гэх мэтээр түүхэн сэдэвт романд,

“машуурах бялуурах” гм-ээр хоршоо үгэнд, **“маш дэлгэр хангай минь мал сүргээр дүүрэн...”** (Ц.Дамдинсүрэн)гм-ээр бичиг зохиолд, **“маш бат, маш тунгалаг”** гм-ээр төрийн албаны тамган дээр сийлж бичиж хэрэглэж ирсэн байна. Жишээлбэл: шашин төрийг хослон баригч Нарангэрэлт Богд хааны мөнгөн эрдэнэ тамганы (1911) дээд талд болон дөрвөн талд нь “Тэнгэр энх, Түвшин дэлхий, Төр маш бат, Шашин маш тунгалаг” хэмээн монгол бичгээр утга төгөлдөр, агуулга гүн бичсэн байдаг. (О.Батсайхан, “Монголын сүүлчийн эзэн хаан ҮШ Богд Жавзандамба”, Уб., 2008, 164-р тал). Нэг. Төрийн тамганд дээд найруулгын үгээр “Төр маш бат”, “Шашин маш тунгалаг” гм-ээр “маш”-аар хэр хэмжээг илэрхийлэн, тодосгон найруулж, их л ёс төгөлдөр, машид хүндэтгэлтэйгээр үйлс бүтээхийг бэлгэшээж бичсэн. Энэ бол монгол хэлний “маш”-ийг хэр хэмжээ, огторгуй–хугацаа заасан хийсвэр утгаар нь нэр үгэнд хамжуулан холбож болдог зүй тогтолтойг харуулж байна.

Нэгэн зүйл: Монголчуудын газар усны нэр, түүнтэй холбоотой домгийн зүйлд **“Жоонын маш хугалдаг”** гэсэн нэгэн сонин домог байдаг бөгөөд энэ домогт Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын нутаг дахь Эрчимийн нурууны салбар Цагаан давааны хойно олон хүн гөрөөлж явжээ. Жооно гэдэг сайн гөрөөчин тосгуулд сууж байтал арван хоёр салаа эвэр нь данхалзсан нэгэн буга хажуугаар нь өнгөрчээ. Үргээлгэнд гарсан хүмүүс Жооно гөрөөчний буудахгүй байгааг гайхсаар очтол нэртэй сайн гөрөөчний маань цахиур бууны маш (гох) нь хугарсан байжээ. Үүнээс хойш Цагаан давааны ар биед байдаг модот уулыг **Жоонын маш (гох) хугалдаг** гэж нэрлэжээ.

Энэхүү домогт буйгаар бол , цахиур бууны гох буюу цахиур бууны бялтыг хавчуулж буудахад гал үүсгэх сойлт төмрийг **“маш”** гэдэг ажээ.

Нэгэн зүйл: Судлаач-эрдэмтний зохиосон язгуурын болон монгол үгийн тайлбар толь бичигт ч дурдаж тэмдэглэж, тайлбарлажээ.

Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь:

Маш- 1.хүч нэмэгдүүлэх үг \онц , нэн, гэсэн утгат хүч нэмэгдүүлэх үг\ маш сайн, маш хурдан явав. Маш хүчтэй, маш цөөн, маш дэлгэмэл\арван дөрвөн оронтой тоо\

2.Цахиур буугийн гал бялтыг хавчуулж буудахад гал үүсгэх хавчуур төмөр.

Машлах- а.юмыг нэг мөсөн болгох

б.хамтатгах, умшлах

в. Юмыг үүрд өгөх, авах

Машуу- хоол хэтэрснээс болж дотор аягүйдэх, гэдэс дотор өвдөх өвчин.

\Уб, 1966, х-336-337\

Монгол хэлний хураангуй тайлбар толь:

Маш - Цахиур бууны гал бялтыг хавчуулж буудахад гал үүсгэх хавчуур төмөр:

Цахиур бууны маш \бялт хавчих төмөр\,

-бууны замаг \бууны маш\

-тэмдэг нэрийн өмнө орж, түүний утгад хүч нэмэгдүүлэх үг, маш дэлгэр\их тэнүүн\, маш эрхэн\охь манлай\.

-маш ногоо \урт өргөн навчтай, дугариг, өндгөлжин хэлбэртэй, хээр талд ургадаг, нэг наст өвс\

Машлах- Хэрэг явдлыг дуусган, эцсийг нь үзэх: Хэзээ ч буцаахгүйгээр өгөх, авах,

- Хамтатгах
- Цахиур бууны машиг сөхөж тавих,, \УБ,2009, х-393-394\
- Буу замаглах,

Машлан барих- \буугаа цэнэглэн барих\

- хэр хэм их, онц, тун
- гал, бууны галтай бялт, хавчуулж буудах сойлтын гох төмөр, замаг ч гэнэ.

Цэцэнцогт. Үгийн язгуурын толь:

Маш- хэр хэм их, дүн онц, маш түгээмэл\өндөр их тоо\,

- гал, бууны галтай бялт хавчуулж буудах сойлтын гох төмөр, замаг ч гэнэ.

Машлах- хэрэг юмыг бүрмөсөн нэг тийш болгох, \Өв Мо, 1987, х-1375\

Хорин наймт тайлбар толь:

Маш- сайнаас сайн хэмээх ба муугаас муу хэмээх тэргүүтэн аливаа үгсийг давхарлан лавлах утгатай. Бас нэн хэмээх үгийн утга ойролцоо амой.

Маш эрхэм- аливаа зүйлийн дээдийн дээдийг маш эрхим хэмээнэ. Бас охь манлай гэнэ.

Маш байх- хөлөлийн нэр: мөнхийн оройд гэрлийн давхарласныг маш байх гэнэ. \ Намжилмаа. Ринчингаваа.ӨВ.МО 1988.х-1170\

Сурагчийн монгол хэлний толь:

Маш- бууны замаг:

Машлах- юмыг нэгмөсөн болгох,

- хамтатгах, умашилах,
- юмыг үүрд өгөх , авах.\Раашдонров. ӨвМо. 1988 х-599\

Д.Баасанбат. Монгол хэлний тунгаамал:

Машан-\машин\- ширээ бөхт мөртлөө хоёр бөх нь хоёул урагшаа муруйсан тэмээг хэлнэ.

Машлах- юмыг нэгмөсөн болгох, юмыг үүрд өгөх авах.

Машуу- хоол хэтэрснээс гэдэс дотор өвдөх өвчин.

- тэмээний өвчин, язартлаа таргалаад хөдөлж чадахгүй тэнтэр тунтар явдаг, хөл нь үеэрээ нугарч өгөхгүй болох ба хулууны өвчин гэж ч хэлж болох. \ Уб.2010. х-173\

Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков:

Машан- средство, орудие: эд зүйл, багаж хэрэгсэл,

Машанга- находчивый опытый \на охоте\: авхаалжтай, хашир,(гөрөөлж явахдаа)

- ловкий, удачливый: овсгоотой, бүтэмжтэй,

Маси дух- покровитель дома- айл гэрийг ивээгч,

М’асида- пошатываться: ганхах, санжганах, өнхөрөх, хөлбөрөх \АКАДЕМИЯ НАУК СССР, Институт языкознания. Ленинград. 1975. Стр-533.Ред В.И.Цинциус.\

Тэгэхлээр энэ цахиур бууны “гох”-ыг нэрлээд байгаа бодот утгатай “маш” гэдэг үг уугуул монгол үг үү, аль эсвэл харь үг үү? Бас тэрчлэн гэдгийн“маш тунгалаг”, маш бат, маш ариун, маш төвшин, маш амрах, маш өгөх, маш байх, машлах” “маш”-тай, бас нөгөө машин тэмээ, машин дэгээ-ний “маш”-тай энэхүү цахиур бууны “гох”-ны “маш”, айдаггүй, эрэлхэг зоригтой,аймшиггүй гэсэн утгатай оноосон нэрийн “маш”, ямар нэгэн сэжмээр холбоо, сүлбээтэй юү? Хийсвэр ба бодот утга заах

талаасаа ямар ялгаатай вэ? эдгээрийн хооронд омоними хэлбэр байна уу? гм олон асуулт гарч байгаа билээ.

Нэгэн зүйл: Монгол хэлний “**маш бат**”, “**маш тунгалаг**”-ийн “**маш**” нь манж-тунгус, зүгийн хэл, зүрчин аялгуунд **үмэси**–“**ümesi**” гэсэн хэлбэрээр, хүчлүүлэх ба эрчимжүүлэх утгатайгаар байдаг аж. Монгол хэлний “**умартах**” гэдэг хэлбэрээс “**ү**” үе –утгалбар хураагдаж, “**мартах**” гэдэг үгийн хэлбэр үүсдэгчлэн, манж хэлний “(“**ümesi**”-ийн, “**ү**” үе-утгалбар хураагдаж, “**mesi**”) буюу “**мэси**” үүссэн бөгөөд монгол хэлний “**маш**”, манж хэлний “**мэси**” хоёр нь гарал,төрөл, хэлбэр, нэр ба үйл үгэнд холбогдож, хийсвэр утга заадаг шинжээрээ холбоо сүлбээтэй, нэг угшилтай гэж үзэж болох үндэс байна.

Нэгэн зүйл: Эртний түрэг хэлний тольд: **Маш**- уйгар бичгээр буй уйгар хууль цаазын бичигт (12-14-р зуун) буддын болон манехейн, бас христийн агуулга, учир холбогдолтой нэгэн бичээст буй оноосон нэр.. Маѣи- и.собств. \USp 49\, ЗХУ-ын ШУА-ийн ИВХО- ийн гар бичмэлийн сангийн баримтад И,собств.,(В.М.Наделяев, Д.М.Насилов, Э.Р.Тенишев, А.М.Щербак, Лен.,1969, стр-338) гэсэн бол,

Орчин цагийн турк тольд:

Маш-хямсаа, чимхүүр, хавчуур, хавчуурга, чимхэж гадагшлуулах зүйл ба хайч, -нэгэн төрлийн шош.\ ауреус\.

Маша кадер -нярай хүүхэд, дөнгөж төрсөн, маш шиг жижигхэн.

Машаши- галын хайч хийж зардаг хүн.

Маша гэсэн перс хэлний гаралтай үг(Монгол-Турк, Турк-Монгол толь, Уб.,2006, “Энпати” төв,338-р тал), “Тюрк Толь”, Анкара, 2000,653-р тал),

TÜRÇE SÖZLÜK:

MAŞA(түркээр)- хямсаа

-галын хайч, галд ямар нэг зүйлийг хавчиж барих хоёр гуятай металл зүйл. Энэ утга перс хэлний үндсэн утга болой. Турк хэлэнд энэ утга одоо ч хэрэглэгдэж байна.

-хямсаа, чимхлүүр

-шилжсэн утга нь: бусдын хэлсэн үгийг өөртөө ашигтайгаар өлгөж авдаг хэн нэгэн хүн .

-үс засах янзлахад зориулсан цахилгаан болон галаар халааж индүүдэх илүүр, индүү, үсний халаах хайч. \Анкара. 2005. 10 дахь хэвлэл. х-1352\

TÜRK DİL KURUMU:

Маш-персээр “**mase** буюу **maasi** гэж дууддаг аж. Үндсэн утга нь галын хайч, галд ямар нэгэн зүйлийг хавчиж барих хоёр гуятай металл зүйл. Шилжсэн утга нь бусдын хэлсэн үгийг өөртөө ашигтайгаар өлгөж, хавчиж, дэгээдэж авдаг хэн нэгэн хүн гэжээ. Тэгэхлээр нөгөө, хүний оноосон нэрийн “**Маш**” тэрчлэн ХҮІ-ХІХ зууны үед хэрэглэж байсан, цахиураас гарах очны үсрэлтээр дарь нь авалцаж, бууддаг цахиур бууны “**гох**”-ны “**маш**”, “**галын хайч**”-ны “**маш**” тэргүүтэн нь перс гаралтай үг болоод байна.(\түрк хэлний хүрээлэн\ Анкара. 2000. X-653)

Эндээс харахад **Нэгд**, монгол хэлний сайнаас муу, муугаас муу хэмээх тэргүүтэн аливаа үгсийг давхарлан лавлах,(Хорин наймт тайлбар тольд тэмдэглэснээр) эрчимжүүлэх ба хүчлүүлэх утгатай “**маш**”, мөн тийм утгат, манж хэлний “**үмэси**”, хүний оноосон нэрийн “**Маш ~ Маши**”, цахиур бууны “**гох**” буюу “бялт хавчих чимхүүр төмөр”-ийн “**маш**”, перс хэлний “**галын хайч**” буюу “**хавчуур**”-ыг заах “**мааси**” г.м. 3-4 “**маш**”-ийн хооронд ижил хэлбэрүүд үүсэж, утга соёлын хэрэглээ нь өвөрмөц онцлогтой болжээ. **Хоёрт**, хүний оноосон нэрийн “**Маш ~ Маши**”, цахиур

бууны сойлт “гох”-ны “маш” нь уугуул монгол үг биш, ормол үг бөгөөд перс хэлний гаралтай “гох, хямсаа, чимхүүр, хавчуур, хавчуурга, галын хайч” г.м. утгыг заан нэрлэсэн “маш ~ мааси”-гаас улбаалан явсаар, утга нь шилжин өргөссөн нь харагдаж байна.

Нэгэн зүйл : Монгол хэл аялгуунаа “маш” хэмээх үгийн хэрэглээ утга нь: “оньс”, “дэгээ”, “цоож”, “цуурга”, “түгжээ”, “тээг буюу тээглүүр”, “гацаа”, “шөрөг”, “шураг”, “замаг”, “гох”, “гөхий”, “чавга” (дөрвөд, захчин аман аялгуунд) “хямсаа”, “хавчуур”, “хайч”, “маш” г.м. цөөнгүй үгс соёлын өөр өөр орчилтой, уг гарвал нь ч өөр, найруулга, хэрэглээний хүрээнд эх сэдвийн синоним байдалтай болж, утгын нэг орон- зүйлд багтан хэрэглэгдэж ирснийг анзаарч болох. Гэхдээ эдгээр үгсийн монгол хэлний үгсийн санд орж ирсэн ул мөр, улбаа учиг, уг гарвал нь өөр өөр, төрөл бүрийн найруулга дахь давтамж, олон янз соёлын хүчин зүйлийн харилцааны илэрхийлэл нь онд ондоо байгаа онцлогтой юм. Тухайлбал, “онь”, “гох”, “гөхий”, “хайч” нь монгол хэлний; “замаг” нь орос хэлний; “цоож” нь хятад хэлний; “цуурга”, “гацаа” нь манж хэлний; “шор”, “шөрөг”, “шураг” нь түрэг хэлний; “дэгээ”, “гэгээ” нь буриад хэлний; “чавга” нь ойрд аялгууны, “маш” нь перс хэлний г.м. өөр өөр ул мөр, уг гарвалтай байх жишээтэй. Тэгэхлээр цахиур бууны “гох” буюу бялт цохих хавчуур төмрийг заадаг “маш” гэдэг перс гаралтай үг, монгол хэлний “галын хайч” – гэдэг үгсийн угсаа – хэлшинжлэл, соёл-хэлшинжлэлийн холбоо, утга соёлын улбаа нь сонирхол татах зүйл юм. **“Бууны гох буюу сойлт хавчуур төмөр”, “Галын хайч”** хоёр холбогдохын учир нарийн ажээ.

Нүүдлийн соёл иргэншилт монголчуудын аман хууль, хорио цээрийн ёсонд **“хайчны цээр”, “бууны цээр”** гэх мэт маш олон тусгай хорио цээр байдаг. Ер, нүүдэлчин, малчин, анчин, гөрөөчин хүмүүсийн гал голомтын ёс, ан авын ёсонд олон бичигдээгүй хууль, ёс горим үйлчилсээр, уламжилсаар ирсэн. Тухайлбал, **бууны цээрт** : Амыг нь дээш харуулан үүрдэггүй. Учир нь дайн байлдаанд явж байгаа цэргүүд бууныхаа амыг дээш харуулан үүрдэг ёстой байжээ. Монгол хүн бууны ам руу үлээдэггүй, зэвэрнэ, чалчина гэж үзнэ. Бууны амыг хүн рүү харуулан өлгөх, тавих, хандуулахыг цээрлэнэ. Бууг хаа хамаагүй тавьдаггүй, тусгай өлгөх, байрлуулах, босгох газартай байдаг. Буунд эмэгтэй хүн, хүүхэд шуухад хүрдэггүй, оролддоггүй байв. Харин уг бууны эзэн нь, эсвэл анчин гөрөөчин хүн л хүрч оролдох ба овоо харааг нь шалгах, оноц цэций нь үзэх, бай буудах, тослох сүмбэдэх, ан авын дараа, олон буудсаны хойно цэвэрлэх тэргүүтэнг хийнэ. Ялангуяа ямар ч бууны овоо хараа, гол төмөр, бууны ам, гох төмөр буюу “маш”, замаг, гал цохих шөвөг төмөр тэргүүтэн бол бүр оролдоод, шохоорхоод байх, хэн хүн, гар хүрээд байх зүйл огт биш. **Машид** эмзэг, гамтай болгоомжтой, цэвэр ариун байлгах дээдийн дээд эд анги болой. Тэгэж баймаажин сайн буу, туршлагатай мэргэн бууч-анчны хүч, ухаанаар л тэр олон зүйл ан ав бүтэмжтэй, урагштай болдог учиртай байж... Бууны хорио цээр, анчны ёс жаягийг дагаж эс чадваас **“буу чалчиж”**, ан авын ажил урагшгүй болдог гэлцэнэ...

Цахиур бууны бялт хавчих төмөр буюу ерөөсөө бууны сойлт **“гох”**-ыг яагаад **“маш”** гэсэн юм бол?, бууны **“гох”**-нд **машид** чухалчилмаар, **машид** хашир хандмаар, онцолмоор ямар ямар шинж байна вэ? гээд л бас нэгэн бодол, тайлбарын сэжүүр гаргаж болмоор. Чингээд бодохлоор, **маш** бат бэх байх, **маш** алдаагүй зөв байх, **маш** цэвэр, зэвгүй тунгалаг байх, **маш** түргэн, оночтой байх, **маш** алдаагүй чалчаагүй байх, **маш** болгоомж сэрэмжтэй байх, ингэснээрээ ан ав нь **маш** бүтэмжит сайн байх ёстой зүйл

бол алив бууны (цахиур буугаар эхэлсэн гэж ойлгоё л доо Б.По) “гох” болно гэж үзэж болмоор.

Бас нүүдэлчин монголчуудын “Хайчны цээр” ч сонин бөгөөд хорио цээр ба “гох”-тойгоо холбогдох талаасаа анхаарал татмаар зүйл байна. “Хайчны цээр”-г:

- Хайч хүүхдэд бариулах, наадахыг цээрлэнэ. Хос үзүүрт мэс нүдэнд халтай, аминд цөвтэй гэдэг.
- Хайч ангархай орхихыг цээрлэнэ. Мэс амь биед осол учруулна, хэл ам татална гэдэг.
- Хайчин дээр гишгэх буюу дээгүүр нь алхахыг цээрлэнэ. Эсгүүр хайчлуур буруудна, их гарз гарна гэдэг.
- Хайчийг хоосон хавшихыг цээрлэнэ. Хутга мэсний үзүүр хүний өөдөөс хандуулсны нэгэн адил ёс алдана хэмээнэ.
- Хайчийг хэрэглээд ил задгай орхих, авдар сав, гэр дээр тавихыг цээрлэнэ.
- Галын хайч гишгэвэл төрөхөд саад гэм болно.
- Хайчны амыг тэлэх буюу хайч ханцуйлж явахыг цээрлэнэ. Үл хэрэгсвээс “Юу алахыг завдана вэ” хэмээн асууж болиулна гэж байна. (Л.Түдэв, “Аман хууль”, Уб, 2000,125-р тал) Тэгэхлээр цахиур бууны сойлт төмөр “гох” буюу “маш”-ийг персээр “мааси” гэсэн. Энд бууны “гох”, “галын хайч” хоёр холбогдоод ирж байх шиг. “Гох”-нд ч маш чухал, дээд цээр байна, “галын хайч”-нд ч эрхэм нандин чухаг цээрүүд байна. “Хайч”-ны цээрийг эс дагаваас хайч гажиж, хайчлах юмаа даахаа больж, бас л чалчиж зажилдаг явдал бий.

Эцэст тэмдэглэхэд, монгол хэлэнд байгаа, тайлбар толь бичигт тэмдэглэгдсэн хэдэн өөр “маш” гэдэг үгийн амь амьдрал, үүсэл гарал, утга соёл, хэрэглээний талбараас нь сонирхож үзвэл, монгол, манж хэлний “маш”, “(mesi)” нь уг гарвал, ул мөр нэгтэй бөгөөд “сайнаас сайн, муугаас муу хэмээх тэргүүтэн” хэр хэмжээний эрчимжүүлэх, хүчлүүлэх хийсвэр утгыг заадаг ба нэр ба үйл үгийн өмнө орохдоо байрлалаасаа болж, хэр хэмжээ, огторгуй-цаг хугацаа, байдал шинж, тоо чанарын утгыг ялган заадаг зүй тогтолтой болжээ. Харин нөгөө бууны замаг-сойлт төмөр буюу “гох”-ыг заадаг, нөгөө талаар “галын хайч”-ийг нэрлэсэн, перс хэлний гаралтай “маш” нь бодит утгыг заах ба энэ үгийг утга олон монгол хэл аялгуунд нэлээд өргөсөн тэлж, “ижил хэлбэрүүд (омоним) үүсэж, утга соёлын өөр өөр орчилд (айдаггүй, эрэлхэг зоригтой, аймшиггүй авхаалжтай, бүтэмжтэй, зэргээс гадна эерэг сэтгэл хөдлөл, сөрөг үнэлэмж, эрхэмлэн хүндэтгэх, цээрлэх утга, машинд эмзэг, гамтай болгоомжтой сэрэмжтэй байх, цэвэр ариун байлгах дээдийн дээд утга), орж яваа юм шиг санагдав. Ер, тэгээд “маш”-ийн эргэн тойронд магадалмаар, судалж нарийвчилмаар, машинд нягталмаар зүйл бас бус байх шиг...

НОМ ЗҮЙ

1. “Монгол үсгийн дүрмийн толь бичиг”, С.Шагж , 1927.
2. “Эрдэийн сан субашид”. 1990.
3. “Чингис хааны цадиг”, Ш.Нацагдорж. 1991.
4. “Монголын сүүлчийн эзэн хаан ҮШ Богд Жавзандамба”, О.Батсайхан, Уб., 2008, 164-р тал.
5. “Монгол хэлний товч тайлбар толь”, Я.Цэвэл. Уб, 1966, х-336-337.
6. “Монгол хэлний хураангуй тайлбар толь”, х-393-394.

7. “Үгийн язгуурын толь”, Цэцэнцогт, Өв Мо, 1987, х-1375.
8. “Хорин наймт тайлбар толь”, Намжилмаа. Ринчингаваа. ӨвМо, 1988.х-1170.
9. “Сурагчийн монгол хэлний толь”, Раашдонров. ӨвМо. 1988 х-599.
10. “Монгол хэлний тунгаамал”, Д.Баасанбат. Уб.2010. х-173.
11. “Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков”, АКАДЕМИЯ НАУК СССР, Институт языкознания. Ленинград. 1975. Стр-533. Ред В.И.Цинциус.
12. “Эртний түрэг хэлний толь”, маѝ- и.собств. USр 49\, ЗХУ-ын ШУА-ийн ИВХО-ийн гар бичмэлийн сангийн баримтад ,И,собств,.В.М.Наделяев, Д.М.Насилов, Э.Р.Тенишев, А.М.Щербак, Лен.,1969, стр-338.
13. “Монгол-Турк, Турк-Монгол толь”, Уб., 2006, “Энпати” төв, 338-р тал.
14. “Тюрк Толь”, Анкара, 2000,653-р тал.
15. “TÜRÇE SÖZLÜK”, Анкара. 2005. 10 дахь хэвлэл. Х-1352 .
16. “TÜRK DİL KURUMU”, түрк хэлний хүрээлэн Анкара. 2000. Х-653.
17. “Аман хууль”, Л.Түдэв, Уб, 2000,125-р тал.

SUMMARY

This article deals with the word “маш” which is used to intensify the power of the phrase on basis of contemporary researches on its etymological, structural, semantic and cultural contents as well as usage examples from dialects of the Mongolian language, traditional legends and customs. Moreover, multiple meanings, collocations and phrases from documentary and literary texts and dictionaries are presented.